



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 61,700,000.00 (жаран нэгэн сая долоон зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 20,000,000.00 (хорин сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Баянгол дүүргийн Прокурорын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга Ш.Эрдэнэбилэг, Баянгол дүүргийн Прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга О.Ганбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

139805309
14-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 05 дугаар сарынөдрийн
 №6 дугаар тогтоолын хавсралт



Улсын Ерөнхий Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй
 ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх
 автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил	Шилжүүлэн хүлээн авах байгууллага
1	Ниссан Теана, улсын дугаар УНУ-0894 Арлын дугаар: 1N4AL3AP0GC184735	2016/2018	1	61,700,000.00	20,000,000.00	2	Баянгол дүүргийн прокурорын газар
Нийт дүн				61,700,000.00 (жаран нэгэн сая долоон зуун мянга)	20,000,000.00 (хорин сая)		